



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/159

Номгон


Төрийн архивын сан хөмрөгт Одон, тэмдэг,  
Төгрөг, мөнгө, Газрын зургийн цуглуулга  
хөмрөг нээх тухай

Төрийн архивын сан хөмрөгийн бүрдүүлэлт, баяжуулалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Төрийн архивын сан хөмрөгт Одон, тэмдэг, Төгрөг, Мөнгө, Газрын зургийн цуглуулга хөмрөг нээсүгэй.

2.Дээрх баримтын төрлөөр тухай бүр бүрдүүлэлт хийж ажиллахыг нийт байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт, хэрэгжилт, арга зүйг зохион байгуулж ажиллахыг Төрийн архив (В.Эрдэнэчимэг) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

